

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2023
оны 12 дугаар сарын 27-ны өдрийн
8чо1 дугаар тушаалын хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

2023. 12. 27

Байгууллагын нэр:

Цагдаагийн ерөнхий газар

Албан тушаалын нэр:

Тасгийн дарга

Ажлын цаг:

8 цаг

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Нэгжийн нэр:

Алба, нэгж, нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын Шуурхай удирдлагын тасаг

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

ТТ-5

Ажлын байрны албан ёсны байршил:

Алба, нэгж, нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын байр

Онцгой нөхцөл:

Байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, хүн, малын гоц халдварт өвчин, террорист халдлага гарсан, гэнэтийн болон бусад аюул тохиолдсон, нийтийн эмх замбараагүй байдал үүссэн, онц болон дайны байдал зарласан, онц ноцтой гэмт хэрэг үйлдэгдсэн зэрэг зайлшгүй тохиолдолд өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллах.

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГҮҮРЭГ:

Албан тушаалын зорилго:

Гэмт хэрэг, зөрчлийн талаарх дуудлага, мэдээллийг хүлээн авах, шийдвэрлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, дун шинжилгээ, судалгаа хийх, шалтгаан нөхцөлийг тогтоох, мэдээлэл, холбоо, технологийн техник хэрэгслийн ашиглалтын бэлэн байдлыг ханггуулж, нэгж, алба хаагчдын харилцан ажиллагааг уялдуулан зохицуулах, эрх бүхий байгууллага, албан тушаалтныг мэдээллээр хангах үйл ажиллагааг зохион байгуулж, байгууллага, алба хаагч бусад ажиллагсдын хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр хэрэгжүүлэх ажилд бүх талын туслалцаа үзүүлэх.

Албан тушаалын зорилт:

- 1.Иргэд, байгууллагаас ирүүлсэн дуудлага, мэдээлэл нэг бүрийг хүлээн авч бүрэн шийдвэрлэх, зарлан мэдээлэх, эрэн сурвалжлах ажлыг зохион байгуулах, хойшлуулшгүй ажиллагаа, хэргийн газрын хамгаалалт, үзлэг зохион байгуулж байгаа байдалд хяналт тавьж, мэргэжлийн удирдлагаар хангах;
- 2.Гэмт хэрэг, зөрчлийн талаарх дуудлага, гомдол, мэдээллийг хүлээн авах, бүртгэх хуваарилах, дамжуулах үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах;
- 3.Мэдээлэл, холбооны технологийн бодлого, зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
- 4.Мэдээллийн сан бүрдүүлэх, хяналт тавих, холбогдох журам, зааврын хэрэгжилтийг хангах, эрх бүхий байгууллага, албан тушаалтныг шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах;
- 5.Байгууллагын дотоод аюулгүй байдал, saatuuulaah, түр saatuuulaah үйл ажиллагаанд хяналт тавьж, мэдээ, мэдээллийг шуурхай дамжуулах үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;
- 6.Хууль тогтоомж, дүрэм, журмаар хүлээлгэсэн ажлын байрны зорилгод нийцсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах –Т Харилсан гүйцэтгэх-Г Хянах-X Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	<p>1.1.Гэмт хэрэг, зөрчлийн талаарх дуудлага, гомдол мэдээллийг хүлээн авч бүртгэх, таслан зогсоох, ул мөрийг хамгаалах учирч болох хор уршигийг гаргуулахгүй, нэмэгдүүлэхгүй байхад чиглэсэн арга хэмжээг шуурхай зохион байгуулах;</p> <p>1.2.Хэргийн газрын үзлэгийн багийн үйл ажиллагаанд холбоо, мэдээлэл, хяналт, шуурхай удирдлага, зохицуулалтын чиглэлээр дэмжлэг үзүүлж, шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах;</p> <p>1.3.Эрх бүхий нэгж, алба хаагчаас гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх чиглэлээр Цагдаагийн албаны тухай хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх хуульд заасны дагуу явуулж байгаа ажиллагааг уялдуулан холбож, шуурхай удирдлагаар хангах;</p> <p>1.4.Хойшлуулшгүй ажиллагаа, зарлан мэдээлэх, эрэн сурвалжлах ажлыг зохион байгуулах, гэмт хэрэг, зөрчлийг таслан зогсоох, илрүүлэх, гэмт хэрэг, зөрчлийн газрыг хамгаалалтад авах, сэргээгдсэн этгээдийг баривчлах зорилгоор тухайн нэгжийн хүч хэрэгслийг шуурхай удирдлага, зохицуулалтаар хангах, үйл ажиллагаанд хяналт тавьж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах;</p>	<p>Ажлын шуурхай, тасралтгүй байдал хангаж, иргэд, хуулийн этгээдээс ирүүлсэн гэмт хэрэг, зөрчлийн талаарх дуудлага, мэдээлэлд тавих хяналт сайжирна</p>	T, Г, Х, Ш T, Г, Х, Ш T, Г, Х, Ш T, Г, Х, Ш

	<p>1.5.Шаардлагатай тохиолдолд байгууллагын удирдлагын зөвшөөрснөөр хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгсэл /суурин утас, үүрэн утас, шуудан, мэдээллийн технологийн бүх төрлийн хэрэгсэл/, эрэн сурвалжлах мэдээллийн самбар ашиглан олон нийтэд зарлан мэдээлэх;</p> <p>1.6.Хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд үүрэг гүйцэтгэж буй авто болон явган эргүүлийн алба хаагчдын үйл ажиллагаанд хяналт тавьж, үүрэг, чиглэл өгч, үр дүнг тооцох;</p> <p>1.7.Онцгой нөхцөл байдлын болон нөхцөл байдал хүндэрсэн үед удирдлагын шийдвэрээр бие бүрэлдэхүүнийг өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэглэлд шилжүүлэх ажлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, нэгж, алба хаагчдын харилцан ажиллагааг уялдуулан зохицуулах;</p> <p>1.8.Гэмт хэрэг, зөрчлийн дуудлага, гомдол, мэдээллийн урсгал, давтамжид дүн шинжилгээ хийж, шуурхай зохицуулалтын арга хэмжээ авах;</p> <p>1.9.Хариуцсан нутаг дэвсгэрийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдалд дүн шинжилгээ, судалгаа хийж, гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг тогтоох, түүнээс урьдчилан сэргийлэх арга зам, цаашдын төлөв байдлыг тодорхойлох, удирдлагыг мэдээллээр хангах үүрэг бүхий Дүн шинжилгээ, судалгааны багаас сар, улирал, хагас бүтэн жилээр гаргасан дүн шинжилгээ, судалгааны ажлын санал зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр дэмжлэг үзүүлж хамтран ажиллах.</p>	T, Г, Х, Ш	
2 дугаар зорилтын хүрээнд	<p>2.1.Гэмт хэрэг, зөрчлийн дуудлага, гомдол, мэдээллийг шуурхай хүлээн авах, бүртгэх, дамжуулах, хуваарилах ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хяналт тавих, үр дүнг тооцож, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах;</p> <p>2.1.Гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлын мэдээ, мэдээллийн бодит байдлыг хангах, нэгж /байгууллага/-ийн удирдлага, дээд шатны байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх ажлыг зохион байгуулах;</p> <p>2.3.Гэмт хэрэг, зөрчлийн дуудлага, мэдээллийг түргэн шуурхай, чирэгдэлгүй хүлээн авах, шийдвэрлэх талаар шинэ санал, санаачилга боловсруулах, холбогдох албан тушаалтанд танилцуулж, шийдвэрлүүлэх;</p> <p>2.4.Гэмт хэрэг, зөрчлийн талаарх дуудлага, гомдол, мэдээллийн бүртгэлийн бодит байдалд хяналт, шалгалт хийж,</p>	<p>Хуулийн хэрэгжилт бүрэн хангагдана</p> <p>Албаны бэлэн байдал хангагдана</p>	T, Г, Х, Ш
			T, Г, Х, Ш
			T, Г, Х, Ш

	<p>бүртгэгдээгүй болон мэдээнд тусгагдаагүй шалтгаан нөхцөлийг тогтоож, зөрчлийг арилгах арга хэмжээ авах;</p> <p>2.5.Гэмт хэрэг, зөрчлийн талаарх өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, бүртгэх, мэдээллийн сан бүрдүүлэх, тэдгээрийн шийдвэрлэлтийн хугацаанд хяналт тавих ажилд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах;</p>		T, Г, Х, Ш
3 дугаар зорилтын хүрээнд	<p>3.1.Мэдээллийн технологи, харилцаа холбооны бодлого, зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;</p> <p>3.2.Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлж буй мэдээллийн систем /программ хангамж/-ийг суурилуулах, тэдгээрийн ашиглалт, мэдээллийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хяналт тавих;</p> <p>3.3.Цагдаагийн төв байгууллагын нэгдсэн сүлжээ, байгууллагын дотоод хяналтын болон гудамж, талбайн төлөх хяналтын системийн ашиглалтын хэвийн байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх;</p> <p>3.4.Мэдээлэл, холбооны технологийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалтын бэлэн байдлыг хангуулах, эвдрэл, гэмтлийг оношлох, засвар, үйлчилгээ үзүүлэх, техник хэрэгслийн бүртгэл хөтлөх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангах.</p> <p>3.5. Холбоо, мэдээллийн инженер /ахлах инженер/-ийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, ажлын ачааллыг оновчтой зохион байгуулах;</p> <p>3.6.Цагдаагийн байгууллагын мэдээллийн технологи, харилцаа холбооны болон цахим мэдээллийн аюулгүй байдал хариуцсан нэгжүүдтэй хамтран ажиллах;</p>	<p>Мэдээлэл, харилцаа холбооны шуурхай, тасралтгүй, бэлэн байдал, техник хэрэгслийн ашиглалтын хэвийн үйл ажиллагаа хангагдана.</p>	T, Г, Х, Ш T, Г, Х, Ш
4 дүгээр зорилтын хүрээнд	<p>4.1.Нутаг дэвсгэрийн хэмжээнд гомдол, мэдээлэл, гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийг бүртгэх, холбогдох мэдээллийн сангуудыг төрөлжүүлэн бүрдүүлэх, тэдгээрийн бодит байдлыг хангах, баяжилт, хөдөлгөөн хийх, статистикийн мэдээлэл бэлтгэх, судалгаа, дүн шинжилгээ хийх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангах;</p> <p>4.2.Нутаг дэвсгэрийн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлын талаар судалгаа, мэдээлэл бэлтгэх, удирдлага, алба хаагчдад танилцуулах, мэдээллийн сангаас шаардлагатай судалгаа, мэдээлэл, лавлагааг гаргах, орон нутгийн өөрөө удирдах болон шүүх, прокурор, хууль сахиулах болон бусад байгууллагуудыг холбогдох мэдээ, мэдээллээр хангах ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангах;</p>	<p>Мэдээллийн сан бүрдүүлэлт, холбогдох журам, зааврын хэрэгжилт хангагдана.</p>	T, Г, Х, Ш T, Г, Х, Ш

	<p>4.3.Мэдээллийн сангийн бүрдүүлэлтийн талаар дээд шатны байгууллага, албан тушаалтнаас өгсөн үүрэг, ажлын чиглэлийг тогтоосон хугацаанд нь хэрэгжүүлж, үр дүнг танилцуулах;</p> <p>4.4.Мэдээлэл, судалгааны ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн нарын ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, шаардлагатай арга хэмжээг авах.</p>		T, Г, Х, Ш
5 дугаар зорилтын хүрээнд	<p>5.1.Байгууллагын аюулгүй байдлыг хангах болон дотоод журмын хэрэгжилтэд хяналт тавих, байгууллагын өмч хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг алдагдахаас урьдчилан сэргийлж, илэрсэн зөрчлийг орон тооны бус ажлын хэсэг, холбогдох албан тушаалтанд мэдэгдэж, зөрчлийг арилгуулах, арга хэмжээ авах, галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохин байгуулж, хяналт тавих, үйлчлүүлж буй иргэдийн баримт бичгийг шалгаж нэвтрүүлэх, шуурхай үйлчлэх ажлыг зохион байгуулах;</p> <p>5.2.Онц ноцтой гэмт хэрэг, байгалийн аюулт үзэгдэл, хүн, малын гоц халдварт өвчний мэдээ, мэдээллийн талаар Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд заасны дагуу холбогдох албан тушаалтныг мэдээллээр хангах;</p> <p>5.3.Саатуулах, түр saatuuulaah үйл ажиллагаанд хяналт тавьж, хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөө, цагдаагийн алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээ зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, илэрсэн зөрчлийг хариуцсан тасгийн дарга, ахлах байцаагч нарт мэдэгдэж, газар дээр нь арилгуулах ажлыг зохион байгуулах;</p> <p>5.4.Жижүүрийн шуурхай албанад ашиглаж байгаа галт зэвсэг, техник, тусгай хэрэгслийн хадгалалт, хамгаалалтад хяналт тавих;</p> <p>5.5.Нийтийг хамарсан арга хэмжээний хамгаалалт, зохицуулалтын үед харилцах, хамтын ажиллагааг зохион байгуулахад хяналт тавих.</p>	Байгууллагын аюулгүй байдал, дотоод журмын хэрэгжилт хангагдана.	T, Г, Х, Ш
6 дугаар зорилтын хүрээнд	<p>6.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлж, тасгийн алба хаагчдаас харилцагч, үйлчлүүлэгчид, иргэдтэй зөв боловсон харьцах, ёс зүйн зөрчил, дутагдал гаргуулахгүй байхад анхаарч хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангах;</p> <p>6.2.Авлига, хүнд суртлаас ангид байж, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн шударга ёсыг эрхэмлэн, "Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг чанд мөрдөх;</p> <p>6.3.Явцуу эрх ашиг сонирхлоос татгалзаж, цагдаагийн байгууллага, албаны нийтлэг эрх ашиг сонирхлыг эрхэмлэн ажиллах;</p>	Удирдлагын тушаал, шийдвэр, үүрэг, албан даалгавар, ажлын чиглэл,	Г

	<p>6.4. Албан хэрэг хөтлөх, үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хяналт шалгалт, тайлагнант, үнэлгээ, дүгнэлт өгөх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангах;</p> <p>6.5. Алба хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж, шалган зааварчлах, үнэлж дүгнэх, мэргэжлийн удирдлагаар хангах;</p> <p>6.6. Хариуцсан нэгжийн ажлыг төлөвлөж, тайлан, мэдээг сар, улирал, хагас бүтэн жилээр гарган дүгнэх, шаардлагатай мэдээ, судалгааг гаргуулан үйл ажиллагааны үр дүнг сайжруулах чиглэлээр бодлого боловсруулж, танилцуулах, шийдвэр гаргуулахад ашиглах.</p>	<p>цагдаагийн алба хаагчийн нийтлэг үүрэг, хууль тогтоомжоор хүлээлгэсэн бусад үүргийн биелэлт хангагдана</p>	<p>Г</p> <p>Г</p> <p>Г</p>
--	---	---	----------------------------

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Дээд боловсролтой, бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх		
Мэргэжил	Эрх зүй /0421/, Иргэн, өмч хөрөнгө хамгаалал /1032/		
Мэргэшил	Мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх.		
Туршлага	Цагдаагийн албан тушаалд томилогдоод 8-аас доошгүй жил, үүнээс хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, мэдээлэл, дүн шинжилгээ, технологийн чиглэлийн ахлах, түүнтэй адилтгах албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх.		
Үр чадвар	Удирдан зохион байгуулах	-Хариуцсан ажлаа төлөвлөх, зохион байгуулах. -Удирдлагадаа байгаа албан хаагчдын ажил үүргийг оновчтой хуваарилах, удирдах чадвартай. -Албан хаагчдын ажлын гүйцэтгэлд өдөр тутам хяналт тавьж, зохих заавар чиглэл өгөх.	
	Дүн шинжилгээ хийх	-Албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулж, дүгнэх -Шийдвэрийн шууд болон шууд бус үр дагаврыг дүгнэх -Гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх, бодитоор үнэлэх	
	Асуудал шийдвэрлэх	-Албан үүргийнхээ дагуу хариуцах ажил үүргийг хууль, тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн гүйцэтгэх	
	Манлайлах	-Ёс зүйгээр хамт олноо манлайлан үлгэр дуурайлал үзүүлэх -Ажил хэргийн хувьд бүтээлч, санаачилгатай ажиллах -Байгууллагын үйл ажиллагааны шинэтгэлийн үзэл санааг хамт олондоо итгүүлэн ойлгуулах, хэрэгжүүлэх	
	Бусад	-Албан хэрэг хөтлөх, баримт бичиг боловсруулах; -Шуурхай зохицуулалт хийх чадвартай байх.	

IV. АЛБАН ТУШААЛЫН ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр: Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дарга	
Албан тушаалд шууд харьялан удирдуулах албан тушаалын нэр, тоо: Батлагдсан орон тоо.	Бусад харилцах субъект: Шууд харилцах байгууллага: Хариуцсан асуудлаар бусад байгууллагын албан тушаалын адил болон түүнээс доош зэрэглэлтэй албан тушаалтан; Шууд бус харилцах байгууллага:

-Төрийн болон төрийн бус байгууллага, иргэд /Эдгээртэй харилцахдаа Цагдаагийн албаны тухай хууль, бусад хууль тогтоомж, үйл ажиллагааны журмын холбогдох заалтыг баримтална/.

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ:

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
Албан тушаал: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭД ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА 2023 оны 12 дугаар сарын 27 -ны өдөр	Байгууллагын нэр: Шийдвэрийн огноо: Дугаар:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

Шийдвэрийн огноо: 2023 оны 12 дугаар сарын 27 -ны өдөр

Дугаар:

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА



Т.СҮХБОЛД

2023 оны 12 дугаар сарын 27 -ны өдөр

ТАНИЛЦСАН:

Албан тушаалтан:

2023 оны дугаар сарын-ны өдөр